

БАТЛАВ:

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах, хэрэгцээ шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ...” гэж иргэн зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах үндсэн эрхүүдийг баталгаажуулсны зэрэгцээ Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж хэрэг, маргааныг бүх шатны шүүх хамтын зармаар хянан хэлэлцэх зарчмыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.1-д заасан “Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана” гэх зорилтын хүрээнд 2021-2030 онд хүрэх үр дүнгийн 3-т “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинэ.” гэж шүүх эрх мэдлийн баримтлах ерөнхий бодлогыг тусгасан. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.1.9-д “Шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно.” гэж, 5.1.11-д “Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлнэ.” гэж шүүх эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг тус тус тодорхой заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.5.Шүүх засаглалын 4.1.5.1-д “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй, шуурхай, үр дүнтэй, хариуцлагатай болгоно.” гэж, 4.1.5.2-т “Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчныг сайжруулж, хараат бус, бие даасан байдлын баталгааг нэмэгдүүлж, шүүгчийн мэргэжлийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ.” гэж, 4.1.5.3-т “Шүүхийн процессыг цахимжуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг ил тод болгож, хэрэг, маргааныг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэнэ.” гэж, 4.1.5.4-т “Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг олон

улсын сайн жишигт хүргэнэ.” гэж, 4.1.5.5-д “Хууль зүйн дэд бүтцийг хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 4.1.5.6-д “Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинэ төрлийн шинжилгээний чанар, үр дүнг олон улсын жишигт хүргэж, шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.” гэж Засгийн газрын шүүх засаглалын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг тухайлан тусгасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-ын 1.1.1-д “Иргэн шүүхэд мэдүүлэх эрхээ баталгаатай эдлэхэд учирч байгаа бэрхшээлийг тодорхойлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгоно” гэж, 2.2.1-д “Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж, 2.2.2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хариуцлагатай, чанартай, үр дүнтэй, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн анхан, давж заалдах шатны шүүхийн зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” гэж, 5.1.6-д “...хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийн баталгааг дээшлүүлнэ” гэж шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг тус тус тодорхойлж, холбогдох арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Улсын Их Хурал, бүх шатны шүүх, холбогдох байгууллагад даалгажээ.

1.2.Практик шаардлага

Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох хүрээнд:

1.Монгол Улсын Үндсэн хуульд бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар, шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэхээр заасан. Харин практикт давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны илтгэгч шүүгч гэх зохицуулалтыг өргөжүүлэн ойлгож, ингэснээр агуулгын хувьд хамтын зарчмыг хязгаарлах хандлага тогтоход хүргэсэн байдлыг засах шаардлага үүссэн.

2.Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргах эрхийг баталгаатай хангахуйц, үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх ёстой. Гэтэл захиргааны хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны ажилбар, үе шат, бүрдэл зэргийг хуульд хангалттай журамлан зохицуулаагүйгээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол үндэстэй эсэх, шүүхийн шийдвэр хууль ёсны байх шаардлагыг хангасан эсэхийг бүрэн, чанартай хянах тогтолцоо бүрдээгүй байна.

3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дах зарим асуудлыг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүх хянах бүрд шүүх хуралдаан хийж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үр нөлөөтэй, шуурхай байх зарчимд нийцэхгүй байна. Түүнээс гадна, шүүн таслах ажиллагааны явцад гарсан шийдвэрийг хянах процесс

нь хэргийг эцэслэн шийдвэрлэх ажиллагаатай нэг ижил байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, давж заалдах шатны шүүхэд ачаалал үүсгэж байгааг өөрчлөх шаардлагатай байна.

Тусгай журмаар шийдвэрлэх маргааны хүрээнд:

1.Гомдлоор үүсэх хэрэг маргааныг 30 хоногт шийдвэрлэх тусгай зохицуулалттай боловч зарим хуулиудад түүнээс богино хугацаанд хянан шийдвэрлэхээр заасныг уялдуулан зохицуулах, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх хугацааг 30 хоногоор сунгаснаас шалтгаалан тендер явагдаж дуусах, шүүхийн шийдвэр үр нөлөөгүй болох эрсдэл үүсэж байгаад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2.Түүнчлэн, салбарын хууль тогтоомжийн өөрчлөлт дагуулж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан зарим өөрчлөлтүүд нь уг хуулийн системчлэлийг алдагдуулсан шинжтэй байгааг засах шаардлага үүссэн. Энэ хүрээнд өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэх бодит үндэслэл, шаардлага тогтоогдохгүй байгаа тул ердийн журмаар хэлэлцэхээр өөрчлөх нь зүйтэй. Монголбанкны ямар төрлийн шийдвэрийг тусгай журмаар хянан шийдвэрлэх нь тодорхойгүй байгаагаас үүдэн бүх шийдвэрийг нь тусгай журмаар хянан шийдвэрлэх буруу хандлага тогтсон байгааг хуульд заасан чиг үүрэгтэй уялдуулан аутентик тайлбар хийх замаар тодорхой болгох шаардлага үүссэн.

Захиргааны хэргийг хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд:

1.Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) 2021 онд батлагдахаас өмнө Улсын дээд шүүх хяналтын журмаар гаргасан бүх гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг байсан. Харин хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор "хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах" зорилгоор уг хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт заасан тодорхой тохиолдлуудад давж заалдах шатны шүүхийн магадлалыг хянан хэлэлцэх зохицуулалттай болсон. Тухайлбал, шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан, эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой зэрэг тохиолдолд хяналтын журмаар хэлэлцэх зохицуулалттай байна.

Үүний дагуу хяналтын журмаар гаргасан гомдлыг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар (найман шүүгч) хэлэлцэж, хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэдэг. Хэрэв тухайн хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 74

дүгээр зүйлийн 74.4 дэх хэсгийн дагуу танхимын таван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ.

Гэвч хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох шүүгчдийн тоо танхимын нийт шүүгчдийн тооноос зөрүүтэй тогтоогдсон байгаа нь "хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах" гэсэн Үндсэн хуулийн болон Шүүхийн тухай хуулийн зорилгод нийцэхгүй үр дүнд хүргэж болзошгүй байна. Тухайлбал, ижил төстэй хэрэг, маргааныг танхим дотор өөр өөр бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэх нь шийдвэрийн хооронд зөрүү үүсгэх, хууль хэрэглээнд ялгаа гарах, улмаар Шүүхийн тухай хуулиар хяналтын шатны шүүхэд хүлээлгэж буй хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүргийг хэрэгжүүлэхэд саад учруулж болзошгүй.

2.Дээр дурдсанаар хяналтын журмаар гаргасан гомдлыг Улсын дээд шүүхийн харьяалах танхим нийт шүүгчийн хуралдаанаараа хэлэлцээд зөвхөн хуульд заасан дөрвөн үндэслэлд хамаарах гомдлуудыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх зохицуулалттай. 2024 онд Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим нийт 479 хэргийн хяналтын гомдлыг хэлэлцэж, 111 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн бол 359 хэргийг хэлэлцүүлэх хуульд заасан үндэслэл бүрдээгүй гэж буцаасан байна.

Одоогийн зохицуулалтын дагуу хяналтын шатны гомдол гаргасан хэрэг бүрийг анхан шатны шүүхээс Улсын дээд шүүх рүү шуудангаар хүргүүлдэг, ойролцоогоор ирүүлсэн хэргийн дөрөвний гурав нь хяналтын шатны хуралдаанаар хэлэлцэгдэхгүй буцаагдаж байна. Үүнээс үзвэл шуудан, захиргааны ажлын үргүй зардал гарч, цаг хугацаа алддаг байдлыг засах шаардлага үүссэн.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд анхан болон давж заалдах шатны шүүх хуралдааны дэгийг нарийвчлан зохицуулсан боловч хяналтын шатны шүүх хуралдааны дэг, процессын онцлогийг зохицуулалтгүй орхисон. Иймд хяналтын шатны шүүх хуралдааныг явуулахдаа давж заалдах шатны шүүх хуралдааны дэгийг жишиг болгон баримталдаг. Энэ нь хэргийн үйл баримтаас илүү хууль хэрэглээний маргааныг авч үздэг хяналтын шатны шүүхийн онцлогт тэр бүр тохирохгүйн зэрэгцээ хэргийн оролцогч нарт дэгтэй холбоотой тодорхой бус байдлыг үүсгэдэг учир дэгээ тогтоох эрхийг Нийт шүүгчийн хуралдаанд олгох зэрэг зохицуулалт хэрэгтэй байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах зохицуулалтын хүрээнд:

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах зохицуулалт нь одоогийн байдлаар шүүхийн шийдвэр гарснаас хойш ямар нэгэн хугацаа, давтамжийн хязгаарлалтгүй байгаа нь нэг ижил үндэслэлээр эсвэл үндэслэлгүйгээр удаа дараа хүсэлт гаргах нөхцөлийг бүрдүүлж байна. Үүний улмаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашрах, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

үндэслэлгүйгээр сунгагдах, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх зэрэг сөрөг үр дагавар гарах тохиолдол нэмэгдэж байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар мэдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргах зохицуулалт байгаа ч үүнээс бусад хугацааны хязгаарлалт, хөөн хэлэлцэх хугацааны талаар тодорхой заалт байхгүй байна. Харин Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон зарим улс орны хууль тогтоомжид энэ төрлийн хүсэлт гаргах хугацааны хязгаарлалтыг тодорхой тогтоосон байдаг.

Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болох Олон Улсын Шүүхийн Дүрэм (*Statute of the International Court of Justice*)-ийн 61 дүгээр зүйлийн 5-д “Шүүхийн шийдвэр гарснаас хойш 10 жил өнгөрсөн бол шийдвэрийг дахин хянахгүй” гэж заасан. БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор энэ хуульд тусгайлсан заалт байхгүй тохиолдолд “Иргэний процессын хууль”-ийг баримтална”, Иргэний процессын хуулийн 456 дугаар зүйлийн 3-т “Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр, эцсийнх болсноос хойш таван жил өнгөрсөн бол шүүх хуралдааныг дахин явуулах хүсэлт гаргахгүй” гэж зааснаар хүсэлт гаргах хугацааны хязгаарлалтыг 5 жилээр тогтоожээ.

ХБНГУ-ын Захиргааны шүүхийн процессын хуулийн 153 дугаар зүйлийн 1-д “Хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу дуусгавар болсон хэргийг Иргэний процессын хуулийн 4 дүгээр дэвтэрт заасны дагуу сэргээж болно” гэж зохицуулсан бөгөөд Иргэний процессын хуулийн 586 дугаар зүйлийн 2-т “...Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жил өнгөрсөн бол хүсэлт гаргах боломжгүй болно” гэж мөн адил 5 жилээр хүсэлт гаргах хугацааг хязгаарлахаар заажээ. Иймд олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн холбогдох зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох нь зүйтэй.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хүрээнд:

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт 2018 оноос хойш тогтмол буурч ирсэн нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээнээс харагдаж байна. Үүнд олон хүчин зүйл нөлөөлж байгаа нь судалгаагаар тогтоогдсон, тухайлбал, хэргийн оролцогчдын зүгээс шүүхийн шийдвэрийн агуулга, хэрэгжилтийг буруу ойлгох, биелүүлэхгүй байх, шүүхийн зүгээс шүүхийн шийдвэрийн Тогтоох хэсэг болон гүйцэтгэх хуудсыг хангалтгүй, ойлгомжгүй бичих, шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс санаачилга, хариуцлага, ур чадвар нь дутагддаг зэргийг дурдаж болно. Гэхдээ эдгээрээс илүү дараах хоёр суурь шалтгаан байгаа.

Тогтолцооны оновчгүй байдал: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий этгээд хариуцагч нь “захиргааны байгууллага” байдаг. Гэтэл захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу Засгийн газрын “хэрэгжүүлэгч агентлаг”, шийдвэр гүйцэтгэгч нь

“захирах, захирагдах ёс” -ны зарчмаар ажилладаг төрийн тусгай албан хаагч байдаг. Үүнээс шалтгаалж дээд шатны байгууллага, албан тушаалтнаас шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг шаардах, албадах эрх нь бодит байдалд хязгаарлагддаг, хэрэгжих боломжгүйд хүрдэг.

Эрх зүйн зохицуулалтын хангалтгүй, үр нөлөөгүй байдал: Өнөөдрийн байдлаар захиргааны шийдвэр гүйцэтгэлийн харилцааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт ердөө л хоёр зүйлээр зохицуулж байгаа бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалт оновчгүй, дутуу, үр нөлөө багатай байна. Дээрх байдлыг засаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг үр нөлөөтэй болгох замаар Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх, зөрчигдсэн эрхээ бодитоор сэргээлгэх нөхцөлийг хангахад зорьсон зохих өөрчлөлт шаардлагатай байна.

Нийтлэг зарим зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд:

1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй, эрх зүйч мэргэжилтэй хүмүүс шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсоноор Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгагдсан хуульчийн баримтлах зарчим, нийтлэг үүрэг, хариуцлагаас зайлсхийх, үйлчлүүлэгчийн өмнө хүлээх мэргэжлийн үүрэг болон мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлахгүй байх эрсдэл үүсэж байна. Мөн эрх зүйч мэргэжилтэй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өөрөө хуульч, өмгөөлөгч авна гэх зэрэг үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр сунжруулах нь шүүхэд мэдүүлэх, шүүхээр хэрэг маргаанаа үр нөлөөтэй, боломжит хугацаанд тасралтгүй, шуурхай шийдвэрлүүлэх зарчимд нийцэхгүй байна.

2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий, зайлшгүй тусгай мэдлэг шаардсан үйл баримтыг тодруулахад шинжээчийн дүгнэлт зайлшгүй шаардлагатай. Гэтэл шинжилгээ хийх үндэслэл бүрдсэн, шинжилгээ хийлгэх шийдвэр гарсан байхад шинжээч нь шинжилгээ хийхээс татгалздаг, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гацаж, тодорхойгүй хугацаагаар удааширч байгааг шийдвэрлэх хэрэгтэй байна.

3.Шүүх нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл тодорхойгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг буцаах (бүрдүүлбэр хангуулахаар) зохицуулалтыг хэт туйлшруулан хэрэглэж хэвшсэн нь шүүхэд хандсан иргэдэд хүндрэл, чирэгдэл үүсгэж, улмаар Үндсэн хуульд заасан шүүхэд мэдүүлэх эрхийг хязгаарлах хэмжээнд хүргэсэн байдлыг залруулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна. Хуулийн төсөлд дараах асуудлуудыг тусгана. Үүнд:

Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох талаар:

1.Хуулийн 118 дугаар зүйлийн 118.5-д заасан шүүгч нь давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааг эрхлэн явуулахаар өөрчлөн найруулна. Хуульд давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн 116¹ дүгээр зүйлийг нэмж, өмнө нь журмаар зохицуулагдаж байсан харилцаа хуулиар зохицуулагдах боломжтой болно. Ингэснээр давж заалдах шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдаан, шүүхийн магадлалын чанар сайжирч иргэдийн шүүхэд мэдүүлэх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгаа сайжрах юм.

2.Давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгчээс “хэргийг илтгэж, танилцуулах” зохицуулалтаас улбаалан хуралдаанд оролцож буй хэргийн оролцогчдын өөрөө шүүхэд мэдүүлэх, мэтгэлцэх эрх цаг хугацаагаар хязгаарлахад хүргэдэг байдлыг засаж, мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг хангах үүднээс “хэрэг илтгэх” гэдэг ойлголтыг халж, хэргийн оролцогчдын өөрсдөө мэдүүлж, тайлбарладаг болгож өөрчлөн найруулна.

3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын шийдвэр буюу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг байдлыг өөрчилж, гомдол, түүнд холбогдох тайлбарыг үндэслэн шийдвэрлэх зохицуулалтыг хуулийн 122 дугаар зүйлийн 122.6-д тусгана. Ингэснээр явцын шийдвэр бүрийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхэд шаардагдах хугацаа хэмнэх, үр нөлөөгүй зохион байгуулалтын шинжтэй ажил, зардал хэмнэнэ. Харин хэргийн оролцогч, өмгөөлөгч нарын бичгээр гаргаж буй гомдол, тайлбарын чанар, үндэслэлтэй байдалд анхаарах, шүүх гомдлын үндэслэл бүрд хариу өгөх замаар баримт бичигт үндэслэн шийдвэрлэх боломж бүрдэнэ.

4.Шүүхийн шийдвэр боловсруулах, гарын үсэг зурах зэрэг асуудлыг Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалаар зохицуулахаар хуулийн 106 дугаар зүйлийн 106.8 дахь хэсгийг хүчингүй болгож, дээрх аргачлалаар нарийвчлан зохицуулна.

Тусгай журмаар шийдвэрлэх маргааны тухайд:

1.Хуульд тусгайлан заасан гомдлоор үүсэх хэрэг маргааныг анхан шатны шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэдэг байхаар хуульчилсан байсныг зарим хуулиудад гомдлыг 30 хоногоос богино хугацаанд хянан шийдвэрлэхээр зохицуулсныг харгалзан үзэж “өөрт нь тусгай хугацаа заагаагүй бол” гэх агуулгаар хуулийн 112 дугаар зүйлийн 112.4.3-ыг өөрчилнө.

2. Монгол банкнаас гаргасан шийдвэр гэдэгт Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Монголбанкны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд гаргасан шийдвэрийг ойлгохоор тайлбар нэмнэ.

3.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохоос татгалзсан шийдвэр болон өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын маргааныг давж заалдах шатны шүүх тусгай журмаар хянан шийдвэрлэх бодит үндэслэл тогтоогдохгүй байх тул анхан шатны шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэдэг байхаар хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.4 дэх заалт болон 113.6 дахь хэсгийг хүчингүй болгосон зохицуулалт орно.

4.Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргааныг түргэн, шуурхай шийдвэрлэх үүднээс хуулийн 112 дугаар зүйлийн 112.6 дахь хэсэгт 30 хүртэл хоногоор сунгах боломжтой байхаар зохицуулсныг 15 хүртэл хоног болгож богиносгоно.

5.Хуулийн нэр, томъёоны агуулгыг жигдлэх зорилгоор хуулийн 113 дугаар зүйлийн 113.5-д тусгагдсан магадлал хяналтын гэсэн хэсгийг шийдвэрт давж заалдах гэж өөрчилнө.

Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор:

1.Хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцэхэд эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой, хууль тайлбарлан хэрэглэсэн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг дахин хэлэлцэх, өөрчлөх шаардлага үүссэн, хэргийг танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх нь зүйтэй гэж танхимын гурваас доошгүй шүүгч үзсэн зэрэг тохиолдолд Танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцдэг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хууль хэрэглээ нэгдмэл байх зарчмын хэрэгжилтийг боловсронгуй болгоно.

2.Хяналтын журмаар гаргасан гомдлыг хэргийн материалын хамт Улсын дээд шүүхэд хүргүүлэхгүйгээр, зөвхөн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, гомдлыг хуульд заасан хугацаандаа гаргасныг нотлох баримт, гомдол гаргах эрхтэй этгээд болохыг нотлох баримтыг хүргүүлдэг болох өөрчлөлт оруулна. Ингэснээр шуудангийн үргүй зардал, зохион байгуулалтын ажил, цаг хугацаа хэмнэнэ.

3.Улсын дээд шүүхээс хяналтын шатны шүүх хуралдааны дэгийг тодорхой болгож, Нийт шүүгчийн хуралдаанд хяналтын шатны шүүх хуралдааны дэг батлах бүрэн эрх олгосон зохицуулалт нэмнэ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах зохицуулалтын талаар:

1.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцүүлэн, хэргийн оролцогчдын эрхийг хязгаарлахгүй байдлаар шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд хүсэлт гаргах хугацааг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор байхаар хязгаарлах, өмнө гаргасан үндэслэлээр дахин хүсэлт гаргасныг хүлээж авахгүй байх зохицуулалтыг нэмнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн талаар:

1.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тухайн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх хариуцдаг болно.

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмыг тодорхой зохицуулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох бүлгийг өөрчилж, хоёр хууль нь харилцан бие биеэ нөхсөн шинжтэйгээр зохицуулах оруулна. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт:

-Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн төрөл, онцлогт нийцсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тусгай журмыг шүүхийн шийдвэрийн төрөл тус бүрээр нарийвчлан зохицуулна;

-Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх аргыг илүү “үр нөлөөтэй” болгох. Үүний тулд бусад улс орны жишигтэй адил шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх зорилгоор “хариуцагчид мөнгөн хэлбэрээр үүрэг хүлээлгэх” зохицуулалт бий болгох. Тодруулбал, хариуцагч шүүхийн шийдвэрийг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүгч тухайн байгууллага, албан тушаалтнаас “... сая хүртэл” төгрөгийг албадлагаар гаргуулах, уг арга хэмжээг хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүртэл дахин авах эрхтэй байхаар заана;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрийн “үргэлжлэл” гэдэг утгаараа шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой шүүхийн шийдвэрт гомдол, нэхэмжлэл гаргахгүй/хязгаарлах байдлаар зохицуулна;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх удирдан явуулах зарчмыг заана.

Нийтлэг зарим зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд:

1.Хуульд төлөөлөгчөөр оролцож болохгүй тохиолдолд “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд” гэж нэмж, гагцхүү хуульч итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор нэмэлтийг оруулна.

2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түргэн, шуурхай байдлыг хангах үүднээс шинжилгээ хийлгэх үндэслэл бүрдсэн буюу шийдвэр гарсан тохиолдолд шинжилгээ хийхээс татгалзах эрхгүй байхаар, мэргэжилтнийг шинжээчээр томилж болохоор хуульд 40 дүгээр зүйлийн 40.3, 40.4 дэх заалтыг нэмж тусгана.

3.Нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл тодорхойгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулдаг, иргэдэд хүндрэл, чирэгдэл үүсгэдгийг халж, шаардлагатай бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодруулах ажиллагаа хийхээр хуулийн 53 дугаар зүйлийн 53.3-ийг өөрчлөн найруулж, 53.5-ийг нэмж тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар шүүн таслах болон шүүн таслах ажиллагаанаас бусад үйл ажиллагааны чанарыг сайжруулах дараах эерэг үр дагавар гарна:

1.Хяналтын шатны шүүх хуралдааныг танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэх зохицуулалтыг хуульд тусгаснаар эрх зүйн шинэ ойлголт тогтоох, хууль хэрэглээг нэг мөр болгох, зөрүүтэй тайлбарыг арилгах боломж бүрдэхийн зэрэгцээ шүүхийн шийдвэрийн эрх зүйн баталгааг сайжруулан, иргэдийн давж заалдах эрхийг бүрэн эдлэх нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой бөгөөд ингэснээр шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, хууль хэрэглээний нэгдмэл байдал хангагдаж, шударга шүүхийн баталгаа сайжирч, иргэдийн шүүхэд итгэх итгэл нэмэгдэнэ.

2.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцүүлэн, хэргийн оролцогчдын эрхийг хязгаарлахгүйгээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах зохицуулалтыг боловсронгуй болгосноор хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой бус байдлыг арилгаж, эрх зүйн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ хүсэлт гаргах хугацааг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор байхаар хязгаарласнаар хэт удаан хугацааны дараа дахин маргаан үүсгэх, шүүхийн шийдвэрийн хүчинтэй байдал алдагдах, шийдвэр биелэгдэхгүй байхаас сэргийлж, өмнө гаргасан үндэслэлээр дахин хүсэлт гаргасныг хүлээж авахгүй байх зохицуулалт нь шүүхийн үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулж, хууль зүйн тодорхой, нэг мөр байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.Хяналтын журмаар гаргасан гомдлыг хэргийн материалын хамт Улсын дээд шүүхэд хүргүүлэхгүйгээр, зөвхөн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, гомдлыг хуульд заасан хугацаандаа гаргасныг нотлох баримт, гомдол гаргах эрхтэй этгээд болохыг нотлох баримтыг хүргүүлдэг болгосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хурдыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх процессын шат дамжлагыг оновчтой болгож, шаардлага хангасан гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, захиргааны зардлыг хэмнэнэ.

4.Улсын дээд шүүхээс хяналтын шатны шүүх хуралдааны дэгийг тодорхой болгож, дэг батлах бүрэн эрхийг олгосноор хяналтын шатны шүүх хуралдааны үйл явц илүү тодорхой болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвшил, тогтвортой байдал хангагдахын зэрэгцээ шүүхийн шийдвэрийн чанар, хууль хэрэглээний нэг мөр байдлыг сайжруулж, эрх зүйн тодорхой байдлыг нэмэгдүүлэх боломжтой болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийн төсөлтэй холбогдуулан гарах бусад хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж, уялдсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

--oOo--